



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ШАРГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 07 өдөр

Дугаар А/04

Баянгол

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Газрын тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баянгол багийн Хадлангийн талбайд хэмжилт хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Х.Төртүлга /Засаг даргын орлогч/

Нарийн бичгийн дарга: Б.Гэрэлт-Од /Газрын даамал/

Гишүүд: Э.Баярцэнгэл /Баянгол багийн ИНХ-ын дарга/

Б.Баярмаа /Баянгол багийн Засаг дарга/

Б.Гантулга /МЭҮТ-ийн мэргэжилтэн/

Б.Оюунтүлхүүр /БОХУБайцаагч/

Б.Шинэхүү /Байгаль хамгаалагч/

Б.Бүрдэлбат /ИТХ-ын төлөөлөгч/

О.Зинээзэг /ИТХ-ын төлөөлөгч/

Г.Ариунбаяр /ИТХ-ын төлөөлөгч/

Н.Очирбат /Зэрэглээт Шарга ХХК-ий захирал/

Р.Дагвадорж /Ус-Алтай ХХК-ий захирал/

Ж.Батбаяр /Их зэгстэйн гол МБ-ийн ахлагч/

2. Хадлангийн талбайгаас хадлан авах бололцоотой хэсгийг тодорхойлж газар эзэмшигчдэд хуваарилж өгөхийг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд даалгасугай.

3. Эзэмшигчидтэй гэрээ байгуулж, гэрээний үүргийн хэрэгжилтийг хангуулж ажиллахыг газрын даамал /Б.Гэрэлт-Од/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



М.ТУНГАЛАГТАМИР

C/barimt/zahiramj/2017

00700010



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ШАРГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/05

Баянгол

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 202 дугаар тогтоолын 3 дахь заалт, сумын Засаг даргын зөвлөлийн 2017 оны 01 үгээр сарын 30-ны өдрийн 01 дүгээр хурлын шийдвэрийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Сумын аварга малчин шалгаруулах журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. "Сумын аварга малчин", "Тэргүүний тариаланч", "Тэргүүний хадланч", "Сумын алдарт уяач"-дыг шагнахад шаардагдах хөрөнгийг жил бүр орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж байхыг санхүүгийн албаны дарга /Н.Гэрэлмаа/-д даалгасугай.
3. Журамд заасан шалгуур үзүүлэлтийн дагуу шагналын материалыг бүрдүүлж хугацаанд нь ирүүлж байхыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.
4. Багаас ирсэн малчдын ажлын үзүүлэлтийг журмын дагуу эрэмбэлэн сумын Засаг даргын зөвлөлд танилцуулж ажиллахыг мал эмнэлэг үржлийн тасгийн дарга /Х.Даваацэрэн/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



М.ТУНГАЛАГТАМИР

C/barimt/zahirami/2017

0070001

Сумын Засаг даргын 20.17 оны 02
дугаар сарын 17-ны өдрийн 1/15 дугаар
захирамжийн хавсралт

"СУМЫН АВАРГА МАЛЧИН" ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Зорилго: Мал сүргийн тогтвортой өсөлтийг хангаж, малын ашиг шим, үүлдэр угсааг сайжруулах, мал аж ахуйн материаллаг баазыг бэхжүүлэх, хэрэгцээт өвс, хадлан тэжээлээ бүрэн бэлтгэж авсан сумын аварга малчинг энэхүү журмын дагуу жил бүрийн цагаан сарын үеэр шалгаруулж, шагнаж урамшуулна.

Нэг: Шалгаруулах ажлын үзүүлэлт

1. Тухайн суурьт том малын хорогдол гаргаагүй, мал сүргээ төлөөр нь өсгөж, 100 эхээс 85-иас доошгүй хувиар төлөө бойжуулсан, оны эцсийн малаа хонин толгойд шилжүүлснээр 600-гаас доошгүй мал тоолуулсан байна.
2. Малынхаа ашиг шимийг бүрэн ашиглахын зэрэгцээ аймаг, сумаас зохион байгуулсан үзэсгэлэн худалдаанд оролцсон байх.
3. Мал аж ахуйн өвөлжөөлөлт, хаваржаалалтын бэлтгэл ажлыг эртнээс хангаж, малчин өрх бүр 3,0- 5,0 тн хадлан, 0,3 – 0,5 тн гар тэжээл өөрийн хүчээр бэлтгэсэн байх.
4. МАА-н материаллаг баазыг бэхжүүлж, малын хашаа, хороо, уст цэгийг тогтмол засаж тохижуулсан байх
5. Мал сүргээ мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх тарилга, туулгалт, угаалга боловсруулалтанд бүрэн хамруулсан байна
6. Мал сүргээ жил бүр малын индексжүүлсэн даатгалд даатгуулсан байх
7. Малчин өрх ЭМД, НДШ – ийг төлсөн байх
8. Хуц, ухнаа хээлтүүлгийн бус үед ялгалтанд заавал өгсөн байх
9. Сүргийн зохистой харьцааг бүрдүүлж, нийт сүрэгт эзлэх ямааны тоо 50%-иас илүүгүй байна.
10. Сүргийн зохистой бүтцийг бүрдүүлж бод малд хээлтэгч 35%, бог малд 50% -иас доошгүй байх
11. Жилд мал сүргийнхээ 10%-иас доошгүй хувийг эдийн засгийн эргэлтэнд оруулдаг байх өөрийн сумын цөөн малтай 1 малчинг 30-аас доошгүй малаар малжуулсан байх
12. Орон нутгийн бүтээн байгуулалт, нийгмийн хөгжилд 1 сая төгрөгний дэмжлэг туслалцаа үзүүлсэн байх.

Хоёр: Бүрдүүлэх материал

Дээрхи журмын дагуу ажил байдлын тодорхойлолт, ажлын үзүүлэлтүүдийг багийн засаг дарга нар гаргаж, багийн ИНХ-аар хэлэлцүүлэн шийдвэрлэж, материалыг ЗДТГ-ын МЭҮТ-т дараа оны 01 дүгээр сарын 10-ны дотор ирүүлнэ.

Сумын аваргаар 10 хүртэлх малчны материал авна. Баг бүрээс 2-3 хүний материал хүлээн авна.

Гурав: Олгох шагнал

"Сумын аварга малчин" энгэрийн тэмдэг, үнэмлэхний хамт "Сар шинийн битүүлэг" - ний өдөр гардуулна.



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ШАРГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

20 17 оны 02 сарын 21 өдөр

Дугаар А/06

Баянгол

Г Хөрөнгө зарцуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалын “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.3 дахь заалт, Засаг даргын зөвлөлийн 2017 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 02 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын аварга малчин, алдарт уяач, мянгат малчны болзол хангасан хавсралтанд заагдсан нэр бүхий малчдад “Сумын аварга малчин”, Сумын алдарт уяач”, “Сумын мянгат малчин” цол олгож энгэрийн тэмдэг, үнэмлэхээр шагнасугай.

2. “Сумын аварга малчин”, Сумын алдарт уяач”, “Сумын мянгат малчин”-ы энгэрийн тэмдэг, үнэмлэхний үнэнд 324000 төгрөг, сар шинийн баярт зориулсан үндэсний бөхийн барилдаанд 255000 төгрөг, битүүлгэнд 531700 төгрөг, “Аймгийн сайн малчин”-д хүндэтгэл үзүүлэх, өргөмжлөл дурсгалын зүйлд 250000 төгрөг, “Оны шилдэг 9 алдартан”-ы шагналд 405000 төгрөг, орон нутгийн бүтээн байгуулалтанд хувь нэмэр оруулж шинээр байшин барьсан өрхүүдийн шагналд 150000 төгрөг нийт 1915700 төгрөгийг засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргаж зарцуулахыг санхүүгийн албаны дарга /Н.Гэрэлмаа/, нягтлан бодогч /Л.Оюунбилэг/ нарт зөвшөөрсүгэй.

3. Холбогдох тооцоог хавсралтаар гарган санхүүгийн анхан шатны баримтыг бүрдүүлэхийг нярав /Б.Уранцэцэг/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.ТУНГАЛАГТАМИР

C/barimt/zahiramj/2017

00700018

Сумын Засаг даргын 2017 оны 02
дугаар сарын 21 ны өдрийн 4 дугаар
захирамжийн хавсралт

№	Овог нэр	Баг	Энгэрийн тэмдэг, үнэмлэхний үнэ	
Сумын сайн малчин				
1.	Намжил Очирбат	Баянгол	12000	
2.	Баасанхүү Лхагвадорж		12000	
3.	Баасанжав Тэгшбүрэн		12000	
4.	Даш Баттөр		12000	
5.	Гүр Баянмөнх	Хамтын хүч	12000	
6.	Хорлоожав Лхагвадорж		12000	
7.	Пүрэв Батдэлгэр		12000	
8.	Ядам Чимгээ		12000	
9.	Эрдэнэчимэг Ганзориг	Улаантуг	12000	
10.	Заяахүү Баянмөнх		12000	
11.	Лхамцоо Баасан		12000	
12.	Ц.Баясгалан		12000	
13.	Намжил Батжаргал		12000	
14.	Авир Буяндэлгэр		12000	
Сумын алдарт уяач				
15.	Амалжий Жанцан	Баянгол	6500	
16.	Сандаг Баянхүү		6500	
17.	Хаш-Эрдэнэ Төгсбат		6500	
18.	Гооёохүү Баатарсүрэн		6500	
19.	Бадарах Нямдорж		6500	
20.	Дамба Гаравцоо		6500	
21.	Гантулга Пүрэв-Очир		6500	
22.	Түдэв Жаргал		6500	
23.	Намжил Давааням		6500	
24.	Бүдрагчаа Батхуяг		Хамтын хүч	6500
Сумын мянгат малчин				
25.	Базаррагчаа Батсайхан		Хамтын хүч	6500
26.	Пүрэвдорж Энхбаатар			6500
27.	Сугар Дашцэрэн	6500		
28.	Ядамхүү Гэрэлчулуун	6500		
29.	Пүрэвдорж Түвшин	Баянгол	6500	
30.	Содном Тогт		6500	
31.	Тэрбиш Лувсандорж	Сондуулт	6500	
32.	Барамсай Гомбосүрэн		6500	
33.	Ложоо Баасандорж		6500	
34.	Пэрэнлэй Түвшинжаргал		6500	
35.	Ложоо Ганпүрэв		6500	
36.	Гомбодорж Эрдэнэбаатар		6500	

2.

37.	Доржсүрэн Ганболд	Улаантүг	6500
38.	Балдорж Баярсайхан		6500



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ШАРГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 4/07

Баянгол

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2017 оны үндсэн чиглэл боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Р.Оюунчимэг /ЗДТГ-ын дарга/

Гишүүд: Х.Төртулга /Засаг даргын орлогч/

Н.Идэрмөнх /Сургуулийн захирал/

Д.Энхбаяр /Соёлын төвийн эрхлэгч/

Б.Одончимэг /Цэцэрлэгийн эрхлэгч/

С.Цогзолмаа /Эрүүл мэндийн төвийн дарга/

Багийн Засаг дарга нар

2. Үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлийг 03 дугаар сарын 06-наас 03 дугаар сарын 10-ны хооронд үр дүнтэй, чанартай боловсруулахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд даалгасугай.



ЗАСАГ ДАРГА М.ТУНГАЛАГТАМИР

C/barimt/zahiramj/2017

00700016